MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд

Мишэл Филион, Төрийн удирдлагын зөвлөх

Агуулга

- Дүр төрх
- Шашин шүтлэг
- Үндэс угсаа, гарал үүсэл
- Нас
- Бэлгийн чиг баримжаа
- Хөгжлийн бэрхшээлтэй эсэх
- Бусад

mfilion@ign.quebec

Дүр төрх

- Бид бүгд биднийг хэн гэдгийг тодорхойлдог харилцан хамаарал бүхий өөр өөр хүчин зүйлтэй. Үүнийг “харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд” гэж болох юм.
- Жендэрийн дүн шинжилгээ нь хүйс ба жендэрээр хязгаарлагддаггүй. Үүнд бусад хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд болох үндэс угсаа, гарал үүсэл, шашин шүтлэг, нас, оюун санааны болон бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй эсэх нь хэрхэн харилцан хамаарч, нөлөөлж байна вэ гэдгийг авч үзнэ.

mfilion@ign.quebec

Шашин шүтлэг

- Шашин бол аливаа хүний дүр төрхийн хувьд гол зүйл билээ.
- Шашин гэдэг үг нь “хамтад нь уях буюу холбох" гэсэн утгатай Латин үгнээс гаралтай.
- Толь бичигт үүнийг "оршин байгаа эсвэл ер бусын зүйлийг шүтэх итгэл үнэмшил, зан үйлийн зохион байгуулалттай тогтолцоо" гэж тодорхойлсон байдаг.
- Аливаа шашин шүтэх нь итгэл үнэмшлээ хуваалцах, зан үйлд оролцохоос илүүтэйгээр нийгмийн нэг хэсэг, заримдаа соёлын нэгээхэн хэсэг болох талтай байдаг.

mfilion@ign.quebec

Үндэс угсаа

- Үндэс угсаа нь тодорхой бүлэг хүмүүсийн хоорондын харилцааны орчил юм. Энэ нь янз бүрийн байдлаар нөлөөлдөг түүх, газарзүй, биологийн нөхцөлөөс улбаатай зүйл юм.

mfilion@ign.quebec

Гарал үүсэл

- Арван долдугаар зуунаас үүсэлтэй нийгмийг анги давхаргад хуваах үзэгдэл юм. Энэ нь “арьсны өнгөтэй” адил ойлголт бөгөөд АНУ-д удаан хугацааны турш хүний дүр төрхийг тодорхойлох гол эх сурвалж болжээ.

mfilion@ign.quebec

Бэлгийн чиг баримжаа

- Бэлгийн чиг баримжаа нь таныг хэнд татагддаг, хэнтэй харьцаанд орох хүсэлтэй байгааг илэрхийлэх ойлголт. Бэлгийн чиг баримжаанд гей, лесбиян, эсрэг хүйстнээ сонирхогч, бисексуал, бэлгийн харилцаанд оролцох сонирхолгүй зэрэг ордог. Олон хүний хувьд энэ нь хэн болохыг тодорхойлох гол зүйл байдаг.

mfilion@ign.quebec

Хөгжлийн бэрхшээл

- Хөгжлийн бэрхшээл нь хувь хүнийг заримдаа ялгаварлал, гадуурхалт, алагчилалд өртөмтгий цөөнхийн бүлэгт багтахад хүргэдэг тусгай хүчин зүйл юм.

mfilion@ign.quebec

Боловсрол

- Хувь хүний дүр төрх болон боловсрол нь хоорондоо нягт уялдаатай.
- Боловсрол нь суралцаж буй хүнийг хэн болохыг тодорхойлдог хүчин зүйл бөгөөд боловсролоор хүн өөртөө дамжуулан давуу талыг бий болгож чадна.
- Боловсролын түвшин доогуур иргэд өөрсдийгөө дорд үзэж, үнэлэх хандлагатай байдаг.

mfilion@ign.quebec

Орлого

- Мөнгө нь хүмүүсийн өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг хэрэгсэл.
- Хүмүүс юуг, яагаад худалдаж авдаг, мөнгөний талаар ярьдаг эсэх болон хэнд ярьдаг нь тэднийг ямар хүн болохыг тодорхойлдог.
- Хүмүүс мөнгөгүй эсвэл элбэг хангалуун байх нь тэдний биеэ авч явах байдал болон төрийн бодлогоос тэдэнд үзүүлэх үр нөлөөнд шууд нөлөөлдөг байна.

mfilion@ign.quebec

Соёл

- Соёл бол тухайн бүлэгт хамаарах дүр төрх эсвэл мэдрэмж юм.
- Тухайн хүн өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө үзэх үзлийн нэг хэсэг бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц соёл бүхий нийгмийн аль нэг бүлэг, эсвэл үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн анги давхарга, үе, нутаг устай холбоотой байдаг.

mfilion@ign.quebec

Газарзүйн байршил буюу амьдарч буй газар

- Газарзүйн байршил нь бидний сонгож авсан мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагаа, хоол тэжээл, хүмүүсийн харилцаанд хүртэл нөлөөлдөг.
- Газарзүй нь хувь хүнийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Амьдарч буй бүс нутаг, уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан тухайн хүний дүр төрх төлөвшдөг.
- Амьдралын талаарх үзэл бодол, тэдний үнэт зүйлс, хүлээлт нь газарзүйн нөхцөл байдлаас хамаардаг.

mfilion@ign.quebec



Merci.